

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](#)  
Өлгий хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл  
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Аудитор: Х.Манаргүл  
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	24,991,339.16	110,071,648.17
	Касст байгаа бэлэн мөнгө	4,397,280.52	13,846,289.75
	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,594,058.64	96,225,358.42
1.1.2	Төлбөртэй үйлчилгээний авлага	232,143,956.27	325,236,143.04
1.1.4	Бусад авлага	818,500.00	1,463,500.00
1.1.6	Бараа материал	86,148,899.42	70,357,077.20
1.1.10	Урьдчилж гарсан зардал	13,389,742.94	13,389,742.94
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>357,492,437.79</b>	<b>520,518,111.35</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,673,684,803.56	9,106,800,093.17
1.2.2	Биет бус хөрөнгө	6,256,499.84	6,127,699.76
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>8,679,941,303.40</b>	<b>9,112,927,792.93</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,037,433,741.19</b>	<b>9,633,445,904.28</b>
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	396,586,417.66	568,838,648.26
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>396,586,417.66</b>	<b>568,838,648.26</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	594,472,238.34	422,220,007.74
2.1.2.2	Зээлийн хүүгийн өглөг	33,900,871.25	33,900,871.25
2.1.2.5	Бусад өглөг	245,840,624.08	36,167,482.11
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>874,213,733.67</b>	<b>492,288,361.10</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,270,800,151.33</b>	<b>1,061,127,009.36</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>4,475,758,318.17</b>	<b>5,091,050,561.17</b>
2.3.1	Өмч:-төрийн	4,475,758,318.17	5,091,050,561.17
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,505,765,988.90	4,505,765,988.90
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,214,890,717.21)	(1,024,497,655.15)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>7,766,633,589.86</b>	<b>8,572,318,894.92</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,037,433,741.19</b>	<b>9,633,445,904.28</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,668,826,417.70</b>	<b>2,339,808,442.93</b>
2	Борлуулалтын өртөг	1,253,890,606.21	1,572,567,966.87
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>414,935,811.49</b>	<b>767,240,476.06</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	271,883,400.91	359,091,798.79
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	234,662,114.70	197,460,003.65
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(91,609,704.12)</b>	<b>210,688,673.62</b>
19	Орлогын татварын зардал		20,295,611.56
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(91,609,704.12)</b>	<b>190,393,062.06</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(91,609,704.12)</b>	<b>190,393,062.06</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(91,609,704.12)</b>	<b>190,393,062.06</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,475,758,318.17	4,505,765,988.90	(1,214,890,717.21)	7,766,633,589.86
11	Залруулсан үлдэгдэл	4,475,758,318.17	4,505,765,988.90	(1,214,890,717.21)	7,766,633,589.86
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			190,393,062.06	190,393,062.06
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	615,292,243.00			615,292,243.00
17	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	5,091,050,561.17	4,505,765,988.90	(1,024,497,655.15)	8,572,318,894.92

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ	1,764,488,910.68	2,480,127,334.23
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,764,488,910.68</b>	<b>2,480,127,334.23</b>
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,717,776,937.31</b>	<b>2,347,945,736.62</b>
	Ажиллагчдад төлсөн	679,213,172.45	890,361,821.41
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	219,603,201.00	277,234,267.64
	Ашиглалтын зардалд төлсөн	287,925,299.19	317,717,142.93
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	209,115,407.24	237,243,759.15
	Татварын байгууллагад төлсөн	220,996,225.24	501,887,121.31
	Даатгалын төлбөрт төлсөн	70,500.00	6,022,825.00
	Бусад мөнгөн зарлага	100,853,132.19	117,478,799.18
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>46,711,973.37</b>	<b>132,181,597.61</b>
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>36,768,352.80</b>	<b>47,101,288.60</b>
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	36,768,352.80	47,101,288.60
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(36,768,352.80)</b>	<b>(47,101,288.60)</b>
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,943,620.57	85,080,309.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,047,718.59	24,991,339.16
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,991,339.16	110,071,648.17

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 ОНӨААҮГ, түүний үйл ажиллагаа**

##### ***ОНӨААҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баян-Өлгий аймгийн нийтийн ахуйн үйлчилгээний “Суат” орон нутгийн өмчийн ХХК-ийн зорилго нь хэрэглэгчдийг ундны ахуйн стандартын шаардлага хангасан цэвэр усаар найдвартай хангаж, хэрэглээний явцад гарсан бохир усыг татан зайлуулж, хөнгөн шуурхай, сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Өлгий сумын хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн ундны ахуйн цэвэр усаар хангах, гарсан бохир усыг зайлуулан цэвэрлэх, нийтийн халуун усаар үйлчлэх, инженерийн байгууламжийн жигд найдвартай ажиллагааг хангах, гарсан авар ослыг богино хугацаанд арилгаж усны алдагдлыг багасгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувь орон нутгийн өмч байна.

#### **3.2 ОНӨААҮГ-ын гадаад, дотоод орчин**

##### ***ОНӨААҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Баян-Өлгий аймгийн нийтийн ахуйн үйлчилгээний “Суат” ХХК нь Компанийн тухай хууль, Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 87 дугаар тогтоолоор “Суат” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг шинэчлэн баталсан ба 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж ажилласан байна.

“Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “НААҮ-ний СУАТ ХХК-ийн орон тоо, цалингийн сан, ажилчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай” шинээр баталсан байна.

“Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Суат” ХХК-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг батлах тухай” тогтоол гарган шинээр баталсан байна.

Тайлант хугацаанд “Суат” ХХК -ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Суат” ХХК-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Тус компанийн захирлын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж ажилласан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Суат” ХХК-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 596.0 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,991.3	110,071.6	85,080.3
Авлага	232,962.5	326,699.6	93,737.2
Бараа материал	86,148.9	70,357.1	(15,791.8)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13,389.7	13,389.7	-
Үндсэн хөрөнгө	8,679,941.3	9,112,927.8	432,986.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,037,433.7</b>	<b>9,633,445.9</b>	<b>596,012.2</b>
Өр төлбөр	1,270,800.2	1,061,127.0	(209,673.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,766,633.6	8,572,318.9	805,685.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>9,037,433.7</b>	<b>9,633,445.9</b>	<b>596,012.2</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 110.1 сая төгрөг болж 85.1 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс кассын үлдэгдэл 13.8 сая төгрөг, арилжааны банкны үлдэгдэл 96.2 сая төгрөг байна.

Авлагын дансны үлдэгдэл 326.7 сая төгрөг болж 93.7 сая төгрөгөөр буюу 40.2 хувиар нэмэгдсэн нь айл, өрхийн авлага 19.4 сая төгрөг, төсвийн байгууллагуудаас авах авлага 35.9 сая төгрөг, бусад авлага 30.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийг насжилтаар нь авч үзвэл 319.2 сая төгрөгийн авлага нь төлөгдөх хугацаандаа байгаа, 7.5 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн найдваргүй авлага байна.

Авлага дансны үлдэгдэлд 2011 оноос хойш үүссэн, үйл ажиллагаа нь зогссон, дампуурсан аж ахуйн нэгжтэй холбоотой олон жил болсон 7.5 сая төгрөгийн авлагыг найдваргүй авлагаар бүртгээгүй нийт авлага дотор бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 70.3 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр буурсан байна. Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 13.4 сая төгрөг нь олон жил дамжсан зардал бөгөөд эх үүсвэр нь тодорхой бус байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9112.9 сая төгрөг болж 615.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ОНХС-аас хэрэгжсэн нийт төсөвт өртөг нь 208.0 сая төгрөгийн цэвэр усны шугамын 1 ажлыг данс бүртгэлд тусгасан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 264.6 сая төгрөгийн өртөг бүхий цэвэр усны шугам, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 30.0 сая төгрөгийн өртөг бүхий бохир усны шугам, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 99.6 сая төгрөгийн өртөг бүхий 25 квт ын генераторыг орлого авч, тайлант оны 229.4 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1061.1 сая төгрөг болж 209.7 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 568,8 сая төгрөг болж 172.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яам аймгийн орон нутгийн төсвөөс урт хугацаат зээлийн 172.2 сая төгрөгийн өр төлбөрийг суутган төлүүлсэнийг богино хугацаат өглөгөөр бүртгэж тайлагнасан ба үүнтэй холбоотой урт хугацаат зээлийн өр төлбөрийн үлдэгдэл 172.2 сая төгрөг болж буурсан байна.

Эздийн өмчийн данс 805.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дээр дурдсан улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын ОНХС-аар хэрэгжсэн 615.3 сая төгрөгийн хөрөнгийг арга хэмжээг орлого авч данс бүртгэлд тусгасан, тайлант онд 190.4 сая төгрөгийн ашигтай ажилласантай холбоотой байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

#### Хүснэгт 2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
				Төлөв-лөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>		<b>1,668,826.40</b>	<b>2,252,081.40</b>	<b>2,339,808.40</b>	<b>87,727.00</b>	103.9
	Худалдаа үйчилгээний байгууллага	сая.төг	329,041.40	473,835.40	465,667.30	(8,168.10)	98.3
	Төсөвт байгууллага	сая.төг	552,298.80	880,679.30	836,917.30	(43,762.00)	95.0
	Орон сууц Гэр хороолол	сая.төг	477,258.60	600,745.70	656,170.80	55,425.10	109.2
	Халуун ус	сая.төг	230,186.10	226,320.90	296,109.50	69,788.60	130.8
	Бусад борлуулалтын орлого		80,041.50	70,500.10	84,943.50	14,443.40	120.5
<b>2</b>	<b>Нийт орлого</b>		<b>1,668,826.40</b>	<b>2,252,081.40</b>	<b>2,339,808.40</b>	<b>87,727.00</b>	103.9
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	1,668,826.40	2,252,081.40	2,339,808.40	87,727.00	103.9
<b>3</b>	<b>Нийт зардал</b>		<b>1,760,436.10</b>	<b>2,185,424.10</b>	<b>2,149,415.34</b>	<b>(29,343.06)</b>	98.4
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	1,488,552.70	1,781,149.30	1,777,760.50	(3,388.80)	99.8

б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	271,883.40	397,609.10	351,359.24	(46,249.86)	88.4
д) Орлогын албан татвараас бусад татвар	сая.төг		6,665.70	20,295.60	20,295.60	304.5
<b>4 Цэвэр ашиг, алдагдал</b>		<b>(91,609.70)</b>	<b>66,657.30</b>	<b>190,393.06</b>	<b>117,070.06</b>	<b>5.5</b>

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Суат” ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тушаалаар 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2252.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 2185.4 сая төгрөгөөр баталж, 66.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2339.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2149.4 сая төгрөгийн зардал гарган, 190.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2339.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 87.7 сая төгрөг буюу 3.9 хувиар давсан нь цэвэр, бохир усны шугамд холбогдсон айл, өрх 242, аж ахуйн нэгж 23-аар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2149.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 29.3 сая төгрөг буюу 1.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр ашиг 190.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 117.1 сая төгрөгөөр өссөн нь цэвэр, бохир усны үйлчилгээний тариф нэмэгдсэн, цэвэр, бохир усны шугамд холбогдсон айл, өрх, аж ахуйн нэгж, төсвийн байгууллага нэмэгдсэнтэй холбоотой байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Суат” орон нутгийн өмчийн ХХК-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

“Суат” орон нутгийн өмчийн ХХК -ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дүгээр сарын 14-ны өдрийн 36 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2024 оны санхүүгийн баримтад 2025 оны 2, 3 дугаар сард шалгалт хийсэнтэй холбоотой санхүүгийн баримтуудыг хуулийн хугацааг хожимдуулж ирүүлснээс аудитын тайлан хугацаанаас хожимпож гарсан болно.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг “Суат” ХХК-ийн 2023 оны нийт зардал 1293.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 25.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх шатанд “Суат” ХХК-ийн 2024 оны нийт зардал 2149.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 42.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон. Нийт зардалд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нэгдсэн удирдамжаар нийцлийн аудит хийгдэж байгаа тул “Суат” ХХК-ийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитаар шалгаагүй болно.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 376.1 сая төгрөгийн 32 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 1253.1 сая төгрөгийн 101 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь мэдээлсэн байна. Тайлант онд 435.5 сая төгрөгийн гурван мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол хоёр мэдээллийг мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 94.0 хувьтай байна.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагад 2024 онд завсрын аудит хийгдээгүй

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 17.4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосоны хэрэгжилт 97.7 хувьтай, 38.3 сая төгрөгийн зөрчил арилгах нэг албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн, 3 зөвлөмж өгөгдсөнийг санхүүгийн тайлангийн аудитаар давтан шалгахад 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	17436.8	3	16476,8	97.7
Албан шаардлага	1	38302.3	1	38302.3	100
Зөвлөмж	3	147200,0	2		66.7
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>202939.1</b>	<b>6</b>	55739,1	<b>88.1</b>

Төлбөрийн актын барагдалт 97.7 хувьтай, албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитаар эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул өмч, хөрөнгийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 7.7 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт байгууллагаас авах авлагыг 6.4 сая, ААНэгжээс авах авлагыг 1.3 сая төгрөг бүгд 7.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав

Аудитаар нийт 585.6 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 150.1 төгрөгийн албан шаардлага, 435.5 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

##### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар 150.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1.Тайлант онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөр тооцоо хийх, ажилтнуудад цалингийн урьдчилгаа олгох зэрэг гүйлгээнд нийтдээ 150.1 сая төгрөгийг мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр хийсэн, оны эцэст касст 13.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “бэлэн мөнгөний кассаар дамжуулан их хэмжээний зарцуулалт хийсэн зөрчлийг арилгах. төлбөр тооцоог зөвхөн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бэлэн бусаар гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах” талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”, 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 17 дугаар зүйлийн 17.1.2-т “холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Аудитаар 435.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант онд гурван мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 435.5 сая төгрөгийн хоёр мэдээллийг мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 94.0 хувьтай байна.

##### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 4.1.4, 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах.

*Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байдлын тайланд авлагыг зөрүүтэй тайлагнасан	1				1	7,732.5	1	7,732.5				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7,732.5</b>			<b>1</b>	<b>7,732.5</b>	<b>1</b>	<b>7,732.5</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Кассаас их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ гаргасан	1	150,146.4			1	150,146.4						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>150,146.4</b>			<b>1</b>	<b>150,146.4</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй	1	435,550,660					1	435,550,660
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>435,550,660</b>					<b>1</b>	<b>435,550,660</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>435,550,660</b>					<b>1</b>	<b>435,550,660</b>